



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2025/001/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:

www.audit.mn

Эрдэнэт хот

2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва

Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 85

танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ БУЛГАНЫ
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ В.АДЪЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 1,453.6 сая кВт.ц буюу 400,447.3 сая төгрөгийн цахилгаан эрчим хүч борлуулж, 2,6945.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Борлуулсан цахилгааны 1,127.2 сая кВт.ц буюу 77.5 хувийг уул уурхайн, 162.9 сая кВт.ц буюу 11.2 хувийг үйлдвэр, аж ахуй нэгж, төсөвт газрын, 163.5 сая кВт.ц буюу 11.3 хувийг ахуйн хэрэглээний борлуулалт эзэлж байна. Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлогыг төлөвлөгөөнөөс 16,614.7 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар давуулан биелүүлжээ.

Хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс шинэчлэгдэж, Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 704 дүгээр тогтоолоор тус компанийн мөрдөх дотоод үнэ тарифт өөрчлөлт орсон, мөн эрчим хүчний компаниудад татаас олгохтой холбоотойгоор улсын төсвөөс 2,939.4 сая төгрөгийн орлого хүлээн авсан байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас авах авлага 9,067.1 сая төгрөгөөр өсөж 19,263.6 сая төгрөг болсон нь нийт авлагын эцсийн үлдэгдэл 21,191.8 сая төгрөгийн 90.9 хувийг дангаар эзэлж, оны эхнээс нийт авлага 9,117.6 сая төгрөгөөр өсөхөд голчлон нөлөөлсөн бөгөөд тайлант оны эцэст нийт авлага зорилтот түвшний үзүүлэлтийн төлөвлөгөөнөөс 602.3 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

“Эрчим хүчний төсөл-2”-ийн хүрээнд авсан урт хугацаатай, хөнгөлөлтэй зээлийн эргэн төлөлтөд тайлант онд 1.2 сая ам.доллар буюу 4,125.2 сая төгрөг төлсөн байна. Үүнээс 2,725.8 сая төгрөг нь зээлийн үндсэн төлбөрт, 1,399.4 сая төгрөг нь зээлийн хүү, хөрөнгө баталгаажуулсны хураамжид зарцуулагджээ.

Аудитын гол асуудал

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2024 онд мөрдөх цахилгаан түгээлтийн алдагдлыг шинийн түгээлтийг хассан дүнгээр 14.6 хувиар тогтоож, гүйцэтгэлээр 13.9 хувийн алдагдалтай ажилласан нь нормоос 0.7 хувиар бага хэдий ч нийт түгээлтийн алдагдлыг 3.3 хувиар тогтоосныг, гүйцэтгэлээр 3.6 хувьтай гарсан нь компанийн цахилгаан түгээлтийн алдагдал буураагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Монгол Улсын эрчим хүчний салбар, бүс нутгийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, түгээх компаниудын цахилгаан эрчим хүчний алдагдлыг бууруулж, эдийн засгийн чадавхыг сайжруулах, техникийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын Хөгжлийн Ассоциаци хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн 54.4 сая ам.долларын “Эрчим хүчний төсөл-2” хэрэгжиж байна.

Энэхүү төслийн хүрээнд Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хамаарах 16.2 сая ам.долларын барилга угсралт, хөрөнгө оруулалтын ажлууд 2018 оноос эхэлж 2024 оны жилийн эцсийн байдлаар эдгээр ажлын гүйцэтгэл 99.9 хувьтай бөгөөд гүйцэтгэгч компаниас барилга угсралтын ажлыг гүйцэтгэх боломжгүй ажлуудын үлдэгдэл материал, холбогдох зардлын хамт хүлээн авч, үлдсэн ажлыг өөрсдөө гүйцэтгэхээр нэмэлт гэрээ байгуулан ажиллаж, гүйцэтгэлийн санхүүжилтэд нийт 15.3 сая ам.долларын зээлийг Дэлхийн банкнаас олгосон байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,956,119,359.08	659,248,869.96
1.1.2	Дансны авлага	11,892,244,425.58	20,923,918,491.66
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	113,943,569.67	223,958,744.58
1.1.4	Бусад авлага	68,001,372.16	43,949,782.79
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	11,356,016,132.01	9,715,468,238.67
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,566,744,996.78	549,952,224.11
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	27,953,069,855.28	32,116,496,351.77
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	145,933,524,751.02	129,784,823,796.51
1.2.2	Биет бус хөрөнгө	5,452,678,743.06	5,027,453,849.52
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,506,433,210.20	1,437,826,303.39
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9	Дуусаагүй барилга		26,312,865,561.13
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	152,892,636,704.28	162,562,969,510.55
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	180,845,706,559.56	194,679,465,862.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	11,215,941,726.59	14,692,400,833.41
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,221,293.41	83,064,754.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг	571,999.29	
2.1.1.5	Богино хугацаат зээл		8,348,241,752.40
2.1.1.6	Хүүний өглөг	302,251,391.40	430,247,338.93
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж олсон орлого	228,726,723.66	832,834,379.51
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)		
2.1.1.10	Богино хугацаат өр төлбөр	198,295,539.85	64,378,188.59
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,947,008,674.20	24,451,167,247.15
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	45,122,758,592.44	41,187,114,537.35
2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	45,918,431.45	77,802,038.15
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	5,104,873,288.04	4,868,106,441.99
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	5,313,506,420.15	8,183,267,079.47
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	55,587,056,732.08	54,316,290,096.96
	Өр төлбөрийн нийт дүн	67,534,065,406.28	78,767,457,344.11
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	48,120,648,100.00	48,120,648,100.00
2.3.2	- хувийн		

2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	82,101,273,359.85	81,831,522,105.67
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмч бусад хэсэг	3,033,798,460.00	3,067,422,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-19,944,078,766.57	-17,107,584,147.46
	Эздийн өмчийн дүн	113,311,641,153.28	115,912,008,518.21
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	180,845,706,559.56	194,679,465,862.32

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	411,721,184,991.83	443,643,398,236.45
2	Борлуулалтын өртөг	394,522,465,739.04	418,044,781,620.57
3	Нийт ашиг /алдагдал/	17,198,719,252.79	25,598,616,615.88
4	Түрээсийн орлого	32,352,000.00	55,195,200.00
5	Хүүний орлого	19,828,645.75	74,709,715.07
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,640,320,411.41	4,060,020,820.05
9	Борлуулалт, маркетингийн зардал	8,017,166,901.56	10,825,543,589.43
10	Ерөнхий ба удирдлагын зардал	11,208,287,202.23	14,798,573,400.80
11	Санхүүгийн зардал	732,176,192.84	923,792,975.80
12	Бусад зардал	706,476,154.96	462,259,660.19
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	260,415,608.03	-177,084,043.20
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	5,556,000.00	29,587,281.82
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-1,506,914,533.61	2,630,875,963.40
19	Орлогын татварын зардал	58,868,573.93	234,984,538.11
19.1	Хойшлогдсон татварын зардал (орлого)	-451,245,670.88	-235,541,446.98
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-1,114,537,436.66	2,631,432,872.27
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-1,114,537,436.66	2,631,432,872.27
23	Бусад дэлгэрэнгүй орлого, зарлага	55,127,147.86	63,559,281.24
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	55,127,147.86	63,559,281.24
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-1,059,410,288.80	2,694,992,153.51
1	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 01 сарын 01 үлдэгдэл	48,120,648,100.00	82,785,285,667.29	2,922,450,460.00	-19,370,379,499.83	114,458,004,727.46
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	82,785,285,667.29	2,922,450,460.00	-19,370,379,499.83	114,458,004,727.46
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-1,114,537,436.66	-1,114,537,436.66
5	Бусад дэлгэрэнгүй орлого		55,127,147.86		0.00	55,127,147.86
6	Өмчид гарсан өөрчлөлт			111,348,000.00		111,348,000.00
7	Зарласан ногдол ашиг					0.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-739,139,455.30		540,838,169.92	-198,301,285.38
9	2024 оны 01 сарын 01 үлдэгдэл	48,120,648,100.00	82,101,273,359.85	3,033,798,460.00	-19,944,078,766.57	113,311,641,153.28
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00
11	Залруулсан үлдэгдэл	48,120,648,100.00	82,101,273,359.85	3,033,798,460.00	-19,944,078,766.57	113,311,641,153.28
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,631,432,872.27	2,631,432,872.27
13	Бусад дэлгэрэнгүй орлого		63,559,281.24			63,559,281.24
14	Өмчид гарсан өөрчлөлт			33,624,000.00		33,624,000.00
15	Зарласан ногдол ашиг					0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-333,310,535.42		205,061,746.84	-128,248,788.58
17	2024 оны 12 сарын 31 үлдэгдэл	48,120,648,100.00	81,831,522,105.67	3,067,422,460.00	-17,107,584,147.46	115,912,008,518.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлтүүд	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	464,658,568,505.59	484,641,513,106.24
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	415,783,421,361.73	431,199,157,123.68
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөр		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	43,834,114,322.56	47,714,936,082.29
	Бусад мөнгөн орлого	5,041,032,821.30	5,727,419,900.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	461,832,177,778.14	481,617,890,543.01
	Ажиллагчдад төлсөн	15,217,196,280.47	20,544,518,760.49
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	4,808,902,287.92	7,032,980,323.83
	Бараа материал худалдан авахад төлсөн	427,190,851,592.86	437,053,168,517.25
	Ашиглалтын зардалд төлсөн	128,227,073.51	132,646,654.08
	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,727,210,185.34	2,062,358,471.40
	Хүүний төлбөрт төлсөн	1,945,995,433.28	1,400,092,377.37
	Татварын байгууллагад төлсөн	4,971,320,037.50	6,615,542,287.43
	Даатгалын төлбөрт төлсөн	18,965,057.00	23,769,340.88
	Бусад мөнгөн зарлага	5,823,509,830.26	6,752,813,810.28
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,826,390,727.45	3,023,622,563.23
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	19,828,645.75	74,709,715.07
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө буруулсан		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	19,828,645.75	74,709,715.07
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,419,166,971.00	1,666,303,469.80
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,419,166,971.00	1,666,303,469.80
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Урт хугацаат хөрөнгө эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,399,338,325.25	-1,591,593,754.73
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,105,372.40	2,728,899,297.62

	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	3,105,372.40	2,728,899,297.62
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,105,372.40	-2,728,899,297.62
4	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,423,947,029.80	-1,296,870,489.12
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	532,172,329.24	1,956,119,359.08
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,956,119,359.08	659,248,869.96
	Нийт зөрүү	1,423,947,029.84	-1,296,870,489.12

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Үзүүлэлт	хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү		
				Төлөв - лөгөө	Гүйцэт - гэл	биет	хувь	
1	Худалдаж авсан цахилгаан	сая.кВтц	1,435.9	1,463.2	1,507.5	44.3	3.0%	
	ЦЭХ-ний алдагдал	хувиар	0.0	0.0	0.0	0.0		
		биетээр	сая.кВтц	47.3	48.8	53.9	5.1	10.6%
	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	1,388.6	1,414.4	1,453.6	39.2	2.8%	
2	Нийт орлого	сая.төг	413,679.7	420,899.5	447,862.9	26,963.4	6.4%	
	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая.төг	378,029.3	383,832.6	400,447.3	16,614.7	4.3%
		Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	33,691.9	35,658.4	42,300.6	6,642.2	18.6%
		Татаасын орлого	сая.төг			2,939.4	2,939.4	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	1,958.5	1,408.5	2,175.7	767.2	54.5%
3	Нийт зардал	сая.төг	415,186.6	429,394.3	445,232.0	15,837.8	3.7%	
	Үүнээс:	Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая.төг	374,677.3	378,222.5	394,374.6	16,152.0	4.3%
		Үйл ажиллагааны зардал	сая.төг	39,802.8	50,239.7	49,654.6	-585.1	-1.2%
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	706.5	932.0	1,202.9	270.8	29.1%
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	-1,506.9	-8,494.7	2,630.9	11,125.6	-131.0%	
5	Татварын дараах ашиг /алдагдал/	сая.төг	-1,114.5	-8,494.7	2,631.4	11,126.2	-131.0%	
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал	төгрөг	1.0	1.0	1.0	0.0	-2.6%	
7	Нийт авлага	сая.төг	12,074.2	20,589.5	21,191.8	602.3	2.9%	
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	11,892.2	20,431.0	20,923.9	492.9	2.4%
		Бусад	сая.төг	181.9	158.5	267.9	109.4	69.0%
8	Нийт өглөг	сая.төг	67,534.1	83,409.1	78,767.5	-4,641.6	-5.6%	
	Үүнээс:	Богино хугацаат	сая.төг	11,947.0	20,663.9	24,451.2	3,787.3	18.3%
		Урт хугацаат	сая.төг	55,587.1	62,745.2	54,316.3	-8,428.9	-13.4%
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	655.0	655.0	655.0	0.0	0.0%	
10	Нийт цалингийн сан	сая.төг	17,752.4	24,228.3	24,348.5	120.2	0.5%	
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди	минут	846.0	1,060.0	749.3	-310.7	-29.3%	
12	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	5,439.2	7,952.8	6,250.4	-1,702.4	-21.4%	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 776.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 3.3 сая төгрөгийн 6 төлбөрийн акт тогтоож, 91.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 681.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Албан томилолтоор ажилласан албан хаагчид томилолтын баримт бүрдүүлэхдээ нийт 0.1 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан төлбөрийн баримт хавсаргасан,

2. Өвөрхангай салбарын дарга нь нотлох баримтгүйгээр 0.3 сая төгрөгийн томилолтын зардал өөртөө тооцож авсан,

3. Өвөрхангай салбар 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр кассаас буудлын үнэд 0.8 сая төгрөгийг холбогдох дэмжих мөнгө хүлээн авагчийн бэлэн мөнгөний баримт, ямар ажлаар, хаанаас хэн ирж буудалд байрласан талаар нэмэлт нотлох баримтгүйгээр аймгийн төвийн буудлын өрөөний болон рестораны 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн төлбөрийн баримт хавсарган зарцуулсан,

4. Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн Б/12 дугаар нэмэгдэл олгох тухай тушаалаар автын механикт үндэслэлгүй шийдвэр гаргаж 1.5 сая төгрөгийн цалин илүү олгосон,

5. Сэлбэг худалдан авсан төлбөрийн баримтыг 7 болон 10 дугаар сард давхар хавсарган 0.2 сая төгрөг илүү олгосон,

6. Гаднын байгууллагын 5 ажилтанд нийт 0.4 сая төгрөгийн урамшуулал олгосонд тус холбогдох салбар, эрх бүхий албан хаагчдад хариуцуулан төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

1. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсантай холбогдуулан гаргасан аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 18-ний өдрийн А/767 дугаар захирамжийг үндэслэн нийт 33.7 сая төгрөгийн урамшууллыг сар болон жилийн үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон,

2. Гүйцэтгэх захирлын шийдвэр гарган тайлант онд нийт 58.2 сая төгрөгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан тул давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өвөрхангай салбар комиссын дүгнэлт, шийдвэргүйгээр 119.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан, кассын зарлагын гүйлгээнд мөнгө хүлээн авагчийн кассын орлогын баримт байхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сэлбэг хэрэгслийг холбогдох комиссын шийдвэрийг үндэслэн худалдан авч, солих.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Өвөрхангай салбар Өвөрхангай аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын заалны түрээсийн гэрээг тус төвийн ажилчдын үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулж 2.1 сая төгрөг олгосон байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн гэрээг түрээсэлж буй хөрөнгийн албан ёсны өмчлөгч, эзэмшигчтэй байгуулж байх.

3. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/215 дугаар тушаалаар компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй нийт 151 хэрэглэгчийн 26.2 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний авлагыг найдваргүй авлагад тооцож, зардал бүртгэсэн байна.

Энэ нь Гүйцэтгэх захирлын 2021 оны А/145 дугаар тушаалаар баталсан "Авлага барагдуулах журам"-ын найдваргүй авлагыг данснаас хасах зохицуулалтын 1-д "Найдваргүй авлагын хэмжээг жил бүр шинэчлэн тогтоож, барагдуулах боломжгүй авлагаас хасах дүнг тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд тусгаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан тусгасан байна", 2-д "Батлуулсан найдваргүй авлагын зардлын дүнгээр найдваргүй авлагын нөөцийг байгуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчийн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэх, хэрэглээтэй холбоотой үүсэж буй авлагыг барагдуулах, найдваргүй авлага бүртгэх асуудлыг үйл ажиллагааны онцлогт тохируулан оновчтой зохицуулах, цаашид цахилгаан эрчим хүчний авлагын төлөгдөөгүй хугацаа хэтрэлтийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх асуудлыг холбогдох байгууллагад хандаж гаргах.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Компанийн санхүүгийн тайланд 7,953.9 сая төгрөгийн анхны өртөгтэй, хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 282,927 ширхэг 162 нэр төрлийн 0 үлдэгдэлтэй хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Эрчим хүчний сайдын 2017 оны 46 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагуудын мөрдөх" НБББББ-ийн 9.8-д "... Тодорхойлсон бодит үнэ цэн болон дансны үнийн хооронд материаллаг зөрүү үүсэхгүй байх үүднээс тайлант хугацаа бүрийн эцэст үнэлгээг хийж байх шаардлагатай", ЭБЦТС ТӨХК-ийн НБББББ-ийн 5.5.6-д "Тооцоологдсон элэгдэл нь анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг НББОУС, Үнэлгээний олон улсын стандартын дагуу дахин үнэлнэ. ...", ТӨБЗГ-н 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж

сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, ашиглалтын хугацааг сунгах, тогтоох асуудлыг холбогдох зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын 2023 оны А/144 дүгээр тушаалаар баталсан ЭБЦТС ТӨХК-ийн "Албан томилолтоор ажиллах журам"-ын 5.6-д "Унааны зардлыг тухайн чиглэлд үйлчлэх унтлагын галт тэрэг, нийтийн тээврийн автобусны үнээр тооцон олгох ба баримт нь ажилтны нэр, регистрийн дугаараар бичигдсэн байна" гэж зохицуулсан нь чиглэлийн нийтийн тээвэргүй алслагдсан аймаг, сумдын, албан хаагчдын аймаг, сум дамжин салбартаа ирж ажиллахад баримтгүйгээр, эсвэл харилцан адилгүйгээр унааны зардал олгох нөхцөлийг үүсгэж байна. Мөн томилолтын зардлын төлбөрийн баримтыг тухайн томилолтоор ажиллаж буй ажилтан өөрөө иргэнээр төлбөрийн баримт гаргаж хавсаргаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтын унааны зардлын зохицуулалтыг салбарын онцлогт тохируулан албан ёсны нийтийн тээвэргүй аймаг, сум дамжин ирж ажиллах ажилтнуудын онцлогт тохируулан тодорхой болгож өөрчлөлт оруулж зохицуулах. Ажилтан өөрөө иргэнээр компанидаа төлбөрийн баримт гаргаж буй зөрчлийг арилгах.

6. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд хянах, удирдах боломжтой үндсэн ба нэмэгдэл цалингийн сан, албан томилолтын зардал, гаднын үйлчилгээний хөлс, ажиллагсдын нийгмийн зардал зэргийг нийт 518.9 сая төгрөгөөр хэтрүүлж ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Эрчим хүчний сайдын 2024 оны А/239 дугаар тушаалаар баталсан "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг шинэчлэн батлах тухай" тушаалын 2-д "Компанийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт бүрээр хангах биелүүлж ажиллахыг ЭБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд В.Адъяа"-д үүрэг болгосугай гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахилгаан эрчим хүчний худалдан авалт, борлуулалт, онцгой нөхцөл байдлаас бусад хянах, удирдах, төлөвлөх боломжтой зардлыг зүйл анги тус бүрээр батлагдсан зардлын төсөвт багтааж ажиллах.

7. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Захиалагч нь 0885 АРХ улсын дугаартай кран засварлах 57.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, ЭБЦТС/20240201057 дугаартай ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа өрсөлдөөнийг өрнүүлэх зарчмыг баримтлалгүй, батлагдсан төсөвт багтахааргүй олон эд анги тусгаснаас шалтгаалж, 2024 оны 02 сараас хойш цахимаар зарласан 6 тендерт нэгч оролцогч оролцоогүй байна. Захиалагч тендер ирээгүй шалтгааныг 2024 оны 08 болон 10 саруудад судалж, 2 удаа техникийн тодорхойлолтыг өөрчилж, 2024 оны 11 сарын 18-нд зарласан тендерт 1 оролцогч оролцож, 2024 оны 12 сарын 06-ны өдөр гүйцэтгэх гэрээ байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44.1-д “Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.9-д “Захиалагч өөрийн байгууллагын төсвийн хүрээнд хэрэгжүүлэх төлөвлөгөө хууль тогтоомжид нийцэж буй эсэх, тухайн байгууллагын зорилтыг хангах, үр ашигтай, зөв төлөвлөгдсөн эсэхийг хянан, цахим системээр батална” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах төлөвлөлт, төсөвт өртгийг техникийн тодорхойлолттой уялдуулан оновчтой, үндэслэлтэй боловсруулах.

8. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/11 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний хороо СИП утас нийлүүлэгчийг сонгох ЭБЦТС/20240102006 дугаартай, 218.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтыг НТШ-ийн аргаар цахимаар зохион байгуулж 207.3 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Кибержаал" ХХК-ийн тендерийг /энэхүү тендерт 6 оролцогч материал ирүүлснээс хамгийн өндөр үнийн санал өгсөн/ шаардлага хангасан, хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосныг эсэргүүцэж тус тендерт оролцогч 192.1 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн "Барилга эрч" ХХК-аас гаргасан гомдлыг Сангийн яамнаас хянаж "Барилга эрч" ХХК-ийн барааны үнийн задаргааны 2 дугаар маягтын 3 дахь баганад барааны гарал үүслийг "Монгол улс" гэж, "Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх" гэсэн 11 дүгээр баганад "үгүй" гэж ирүүлснийг гарал үүсэл тодорхойгүй гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй боловч нийлүүлэх барааны Хятад улсын үйлдвэрлэгчийн дистрибьютерийн гэрчилгээ, холбогдох баримтыг тендерт хавсаргаж ирүүлсэн байх тул уг асуудлыг хуулийн 48.2.3-т заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавихыг захиалагчид даалгасан ч үнэлгээний хороо дахин хуралдаж өмнөх шийдвэрээ баталгаажуулсан нь тус 2 компанийн ирүүлсэн тендерийн үнийн саналын зөрүү 15.2 сая төгрөг хэмнэх боломжийг алдсан байна.

Мөн СИП утас /нэмэлт/ нийлүүлэгчийг сонгох ЭБЦТС/20240102070 дугаартай, 2024 оны 08 дугаар сард цахимаар зарласан 92.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт 3 компани оролцож “Кибержаал” ХХК-г шалгаруулан бөгөөд тус тендерийн бусад оролцогч нарт тендерт шалгараагүй шалтгааныг албан бичгээр хүргүүлэхдээ гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнийн дүнгийн мэдээллийг бүрэн гүйцэд, үнэн зөв хүргүүлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 28.2-д “Энэ хуулийн 28.1.2, 28.1.3-т заасан шийдвэрт түүний тендер шалгараагүй, эсхүл татгалзсан үндэслэлийг болон гэрээ байгуулах эрх олгосон оролцогчийн нэр, гэрээ байгуулах үнэ зэргийг зааж оролцогч тус бүрд нэгэн зэрэг мэдэгдэнэ”, 48.2-д “Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ”, 48.2.3-д “үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих”, 50.10-д “Үнэлгээний хорооны дарга үнэлгээний хорооны үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, хурлыг товлох, тогтоосон хугацаанд шуурхай шийдвэр гаргаж, захиалагчид хүргүүлэх, үнэлгээний хороог захиалагчийн өмнө төлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.9-д “Сангийн яам гомдол хянан шийдвэрлэхэд хуулийн 59.10-т зааснаар хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй асуудлаар захиалагчийг хуулийн 48.2.3-т заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавихыг даалгасан бол захиалагч хуулийн 28.1-д зааснаар шийдвэр дахин гаргах эсэхийг шийдвэрлэж, оролцогчид мэдэгдэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Захиалагч хуулийн 48.2.3-д заасан үнэлгээний хорооны зөвлөм хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлэх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	1	0.1	1	0.1								
	1	0.3	1	0.3								
	1	0.8	1	0.8								
	1	1.5	1	1.5								
	1	0.2	1	0.2								
	1	0.4	1	0.4								
	1	33.7			1	33.7						
	1	58.2			1	58.2						
	1	119.0					1	119.0				
	1	2.1					1	2.1				
	1	26.2					1	26.2				
	1	0.0					1	0.0				
	1	0.0					1	0.0				
	1	518.9					1	518.9				
1	0.0					1	0.0					
1	15.2					1	15.2					
Дүн	16	776.6	6	3.3	2	91.9	8	681.4				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
А	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТБОНӨААН	1	1			1				
	НИЙТ	1	1			1				